

40



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/258

Чойбалсан

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 13 дугаар зүйлийн 13.2, 13.3, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чойбалсан хотын хэрэглээний ундны усны чанар, аюулгүй байдалд дүн шинжилгээ, судалгаа хийн дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | | |
|----------------------|-----------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ажлын хэсгийн дарга: | Ч.Оюунаа | -Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга |
| Дэд дарга: | З.Мөнхнайрамдал | -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэндийн боловсролын хяналтын хэлтсийн дарга, эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч |
| Гишүүд: | Г.Дугармаа | -Аймгийн Эрүүл мэндийн газрын эрүүл мэнд статистик мэдээллийн асуудалхариуцсан мэргэжилтэн |
| | М.Баяртунгалаг | -Аймгийн Эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Э.Номин | -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч |


9

010122655

Нарийн бичгийн дарга: Б.Сарнай -Аймгийн эрүүл мэндийн газрын
Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

2.Ажлын хэсгийг удирдан зохион байгуулж, нөхцөл байдлыг тогтоож судалгаа, шинжилгээний дүгнэлт гарган, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ч.Оюунаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН